DBM
ASSET MANAGEMENT

БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

2026

SUSTAINABILITY REPORT



НОГООН САНХҮҮЖИЛТ

НИЙГМИЙН ХӨГЖИЛ

ХАРИУЦЛАГАТАЙ ЗАСАГЛАЛ

Агуулга

Нэр томьёо, товчлол **3**

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ **4**

1. Тайлангийн танилцуулга **5**
1.1 Тайлангийн тухай 5
1.2 Тайлант оны онцлох үзүүлэлт 5
1.3 Гол үр дүн ба төлөв 6

2. Компанийн танилцуулга **7**
2.1 Хөрөнгө оруулалтын менежментийн компани 7
2.2 Удирдаж буй сангууд 8
2.3 Бүтэц, зохион байгуулалт (2026) 9

3. Тогтвортой хөгжлийн стратеги **11**
3.1 Тогтвортой хөгжлийн зорилт ба төрийн бодлоготой уялдуулалт 11
3.2 Тайлант оны гол чиглэл, үр дүн 11
3.3 Ач холбогдолтой сэдвийн үнэлгээ 12

4. Засаглал **13**
4.1 Засаглалын бүтэц 13
4.2 Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт 14
4.3 Ёс зүй, комплайнс, эрсдэл 15
4.4 Санхүүгийн удирдлагыг сайжруулах төлөвлөгөө 17
4.5 Баримт бичгийн тогтолцоо 18

5. Байгаль орчин **19**
5.1 Оффисын үйл ажиллагааны нөлөөлөл 19
5.2 Сангуудын байгаль орчин, уур амьсгалын нөлөө 21
5.3 Сангуудаас хөрөнгө оруулалт хийх төслүүдийн нөлөө (AHURP, ASDIP, MGFC) 22

6. Нийгэм **24**
6.1 Ажилтан, ажлын орчин 24
6.2 ЭХОНОС сангийн жендэрийн төлөвлөгөө 26
6.3 Оролцогч талуудтай харилцах 26

7. Хөгжүүлэх чиглэл **32**

Хавсралт А. GRI ба ISSB лавлагаа **33**

Хавсралт Б. БОНЗ-ын үзүүлэлтийн маягт **34**

Нэр томьёо, товчлол

БОНЗ (ESG)	Байгаль орчин, нийгэм, засаглал
ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
МУХБ	Монгол Улсын Хөгжлийн банк
ТУЗ / ХЭХ	Төлөөлөн удирдах зөвлөл / Хувьцаа эзэмшигчдийн хурал
ХУГ / ҮАЭУГ	Хөрөнгө удирдлагын газар / Үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлагын газар
ЭХОНОСС (EDAF)	Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан хувийн ХОС ХХК
БНХХААБ (GIRAF)	Бүсийн ногоон хүртээмжтэй хөдөө аж ахуйн бизнес хувийн ХОС ХХК
НХС (DBM GDF)	Ди Би Эм Ногоон хөгжил хувийн ХОС ХХК
СЗХ / УБЕГ / УАГ	Санхүүгийн зохицуулах хороо / Улсын бүртгэлийн ерөнхий газар / Үндэсний аудитын газар
ДАМПОУС	Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт
МИК	Монголын Ипотекийн Корпораци ОССК
АХБ	Азийн хөгжлийн банк
УАНС	Уур амьсгалын ногоон сан
МНСК (MGFC)	Монголын ногоон санхүүгийн корпораци
ОНОСХШТ (AHURP)	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл
АСБНХХОХ (ASDIP)	Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр
НЗДТГ / ТХН	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар / Төсөл хэрэгжүүлэх нэгж
ESMF	Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоо
EDGE	Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын стандарт (IFC)
NDC	Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт
Scope 2	Худалдан авсан цахилгаан, дулаанаас үүдэлтэй шууд бус ялгарал

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



Эрхэм хүндэт хөрөнгө оруулагчид, хамтран ажиллагчид, хөгжлийн түншүүд болон нийт оролцогч талууд аа,

Ди Би Эм ассет менежмент ХХК-ийн анхны Байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) тайланг Та бүхэнд хүргэж байгаадаа баяртай байна.

2026 он манай компанийн хувьд тогтвортой санхүүжилтийн чиглэлээр бодит алхмууд хийсэн онцлог жил байлаа. Бид ToC холбоонд элсэж, тогтвортой санхүүжилтийн сайн туршлагыг нэвтрүүлэх эхлэлээ тавин, ногоон болон хүртээмжтэй хөрөнгө оруулалтын боломжуудыг өргөжүүлэхэд анхаарч ажиллав.

Энэ хүрээнд Азийн хөгжлийн банк (АХБ), Уур амьсгалын ногоон сан (УАНС) зэрэг олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудаас санхүүжилт татах зорилготой “Бүсийн ногоон, хүртээмжтэй хөдөө аж ахуйн бизнес” хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулж, “Ди Би Эм Ногоон хөгжил” хувийн хөрөнгө оруулалтын сангаас анхны хөрөнгө оруулалтыг хийж, “Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан” хувийн хөрөнгө оруулалтын санд эхний санхүүжилтийг татаж, хамтран санхүүжүүлэгч байгууллагуудтай гэрээгээ байгууллаа. Эдгээр нь хувийн хэвшлийн хөрөнгийг ногоон хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон нийгмийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтуудтай уялдуулах чухал алхмууд гэж үзэж байна.

Мөн Уур амьсгалын ногоон сангийн итгэмжлэгдсэн байгууллага болох зорилт дэвшүүлж, шаардлагатай бодлого, тогтолцоо, институцийн чадавхыг бүрдүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Бид энэ онд COP17-ын хүрээнд үүсгэн байгуулсан сангийнхаа нээлтийг хийж, хөрөнгө оруулалтын хэлэлцээрийг баталгаажуулах зэрэг ажлуудыг зохион байгуулж, тогтвортой санхүүжилтийн чиглэлээр хэрэгжүүлж буй ажлуудаа олон улсын түвшинд танилцуулах, шинэ хамтын ажиллагааны боломжуудыг хэлэлцэх завшаан тохиосон нь бидний хувьд бас нэгэн чухал үйл явдал байлаа.

Цаашид бид хариуцлагатай хөрөнгө оруулалт, ногоон болон хүртээмжтэй санхүүжилтийг хөгжүүлж, санхүүгийн өгөөжийг байгаль орчин, нийгэмд бий болгох бодит үр өгөөжтэй уялдуулахын төлөө ажиллах болно.

Бидний зорилгыг дэмжиж, хамтран ажиллаж буй хөрөнгө оруулагчид, хөгжлийн түншүүд, хамтран ажиллагчид болон нийт ажилтнуудаа талархал илэрхийлье.

> ***Бид олон улсын хамтын ажиллагаанд тулгуурлан тогтвортой санхүүжилтээр ирээдүйд бодит үнэ цэн бүтээнэ.***

Хүндэтгэсэн,



Л. Тэмүүжин
Гүйцэтгэх захирал, Ди Би Эм ассет менежмент ХХК

хэсэг 01

1. Тайлангийн танилцуулга

1.1 Тайлангийн тухай

Тайлант хугацаа	2026 оны 1 дүгээр сарын 1 – 9 дүгээр сарын 30.
Хамрах байгууллага	Ди Би Эм ассет менежмент ХХК болон түүний үүсгэн байгуулан удирдаж буй «Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан», «Ди Би Эм ногоон хөгжил», «Бүсийн ногоон хүртээмжтэй хөдөө аж ахуйн бизнес» хувийн ХОС ХХК-иуд.
Жишиг, стандарт	Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо, Монголын Хөрөнгийн Бирж, Олон улсын санхүүгийн корпораци, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Тогтвортой байдлын санхүүгийн төвүүдийн олон улсын сүлжээ болон НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн хамтран боловсруулсан “БОНЗ, ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛЫН УДИРДАМЖ” 2022.

1.2 Тайлант оны онцлох үзүүлэлт

3
хувийн ХОС удирдаж байна

93.1%
Засаглалын кодексийн хэрэгжилт (35 ХОМК-иас 3-р байрт)

19
ажилтан

13.35 сая $
2026 онд татан төвлөрүүлж буй дүн

≈3.2 tCO2e
Scope 2 ялгарал (оффисын хэрэглээнд)

5 сая $
2026 онд хийгдсэн тогтвортой хөрөнгө оруулалтын дүн

E
Байгаль орчин

- Оффисын цахилгаан 4,223 кВт·ц (1–9 сар), Scope 2 ≈ 3.18 tCO2e
- Уур амьсгалын ногоон сангаас санхүүждэг, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилт бүхий 3 төслийг хэрэгжүүлж байна

S
Нийгэм

- 11 үндсэн ажилтны 81.8% нь эмэгтэй, ТУЗ-ийн 33.3% нь эмэгтэй
- 2026.03.03-нд бүтэц, орон тоо, албан тушаалын тодорхойлолт шинэчлэгдсэн
- Хагас жилд 7 сургалт, мэргэшлийн арга хэмжээнд хамрагдсан

G
Засаглал

- Ёс зүйн дүрэм шинэчилсэн (2026.03.03)
- Мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөр (2026.09.21)
- Засаглалын кодекс: 93.1%, 35 ХОМК-иас 3-р байр

1.3 Гол үр дүн ба төлөв

Чиглэл	Тайлант оны үр дүн	Төлөв, дараагийн алхам
Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан	✓ Сангийн яам 2026.06.10-нд 4.15 сая ам.долларын эхний татан авалтын хүсэлтийг баталсан, АХБ 2026.08.21-нд эхний татан авалтыг баталгаажуулсан ✓ Арилжааны банкуудтай хамтран ажиллах гэрээ: 5 банк гарын үсэг зурсан ✓ Хөгжүүлэгч сонгох баримт бичгийг НЗДТГ-ын 2026.05.11-ний А/674 захирамжаар баталсан	Бүрэлдэхүүн 2-ын хөгжүүлэгчийн сонгон шалгаруулалтыг хамтран зохион байгуулна, Банкуудтай бондын гэрээ байгуулна
Ди Би Эм ногоон хөгжил	✓ МУХБ-аас 5.0 сая ам.доллартай тэнцэх анхны хөрөнгө оруулалтыг татсан ✓ МНСК-ийн хувьцаа захиалгын болон хувьцаа эзэмшигчдийн гэрээг 2026.06.29-нд байгуулсан, МНСК-д хөрөнгө оруулалт хийгдсэн ✓ Сангийн нэгж эрхийн цэвэр хөрөнгийн үнэ цэн 0.94%-иар өссөн	Үндэсний ногоон лабораторитой хамтарч төслийн сан (pipeline) бүрдүүлж байна
Бүсийн ногоон хүртээмжтэй ХАА-н бизнес сан	✓ СЗХ-ны 2026.05.07-ны №149 тогтоолоор бүртгэгдэж, 05.21-нд УБЕГ-т бүртгүүлсэн ✓ Кастодиан, мэргэжлийн хувь зөвлөхүүдийг сонгож, 2026.04.01-ээс ажиллаж эхэлсэн ✓ Хамтран ажиллах банкуудыг нарийвчилсан үнэлгээгээр сонгосон (4 банк)	Банкуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах, МУХБ-тай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах

ХЭСЭГ 02

2. Компанийн танилцуулга

2.1 Хөрөнгө оруулалтын менежментийн компани

Нэр	«Ди Би Эм ассет менежмент» ХХК
Регистр / улсын бүртгэл	6229697 / 9011659117
ХОМК-ийн тусгай зөвшөөрөл	380/14
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-14200, Эко Интернэйшнл Тауэр, 23 давхар, 2303, 2305 тоот
Холбоо барих	+976 7711-7977; info@dbmamc.mn; www.dbmamc.mn
Удирдлага	Г.Батжаргал, ТУЗ-ийн дарга Л.Тэмүүжин, Гүйцэтгэх захирал

2.2 Удирдаж буй сангууд

Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан

ХЭЛБЭР, РЕГИСТР
Хувийн ХОС · 7164049

СЗХ-НЫ ТОГТООЛ
2024.11.24, №548

КАСТОДИАН
Голомт банк

ХУГАЦАА
10 жил

ГОЛ ЗОРИЛГО
Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл (AHURP)-д хөрөнгө оруулалт хийх

ТӨЛӨВЛӨСӨН САНХҮҮЖИЛТ
95 сая ам.доллар (олон улсын зээлийн гэрээ)

Ди Би Эм ногоон хөгжил

ХЭЛБЭР, РЕГИСТР
Хувийн ХОС · 7203729

СЗХ-НЫ ТОГТООЛ
2025.06.13, №235

КАСТОДИАН
Худалдаа хөгжлийн банк

ХУГАЦАА
10 жил

ГОЛ ЗОРИЛГО
Агаар, орчны бохирдлыг бууруулах, ногоон хөгжлийг дэмжих санхүүжилтийн тогтолцоо, цэвэр технологид суурилсан хөрөнгө оруулалт хийх

ТӨЛӨВЛӨСӨН САНХҮҮЖИЛТ
50 сая ам.доллар, нэгж эрхийн нэрлэсэн үнэ 1 сая ₮;

Бүсийн ногоон хүртээмжтэй хөдөө аж ахуйн бизнес

ХЭЛБЭР, РЕГИСТР
Хувийн ХОС · 7285777

СЗХ-НЫ ТОГТООЛ
2026.05.07, №149

КАСТОДИАН
Хаан банк

ХУГАЦАА
10 жил

ГОЛ ЗОРИЛГО
Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөтөлбөр — хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээ, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх төсөл (ASDIP)-д хөрөнгө оруулалт хийх

ТӨЛӨВЛӨСӨН САНХҮҮЖИЛТ
735 сая ам.долларын хөтөлбөрийн хүрээнд; сангаар 87.5 сая ам.доллар

2.3 Бүтэц, зохион байгуулалт (2026)

ТУЗ-ийн 2026 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 02/26 тогтоолоор Компанийн бүтцийг Хөрөнгө оруулалтын хороо болон 2 газартайгаар шинэчлэн батлсан бөгөөд үндсэн орон тооны дээд хязгаар 15, гэрээт орон тооны дээд хязгаар 10 байхаар тогтоосон. Гэрээт ажилтнууд тодорхой үүрэг, даалгаврын хүрээнд заасан хугацаанд хамтран ажиллана. 2026 оны стратегийн гол чиглэл нь хэрэгжиж буй ХОС-ын үйл ажиллагааг эрчимжүүлэх, шинэ сангуудын суурь судалгаа, төлөвлөлтийг эхлүүлэх, олон улсын түншлэл, гадаад харилцааг өргөжүүлэх явдал юм.



Зураг 1. Компанийн бүтэц, зохион байгуулалт (2026).

Нэгж	Чиг үүрэг	Бүрэлдэхүүн, үндэслэл
Хувьцаа эзэмшигч — МУХБ	Хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг МУХБ-ны ТУЗ хэрэгжүүлнэ (МУХБ-ны ТУЗ-ийн 2025.11.24-ний 37-р тогтоол).	2026 онд ХЭХ-ын ээлжит 1 (04.30), ээлжит бус 2 (03.27, 05.22) хурал; нийт 4 шийдвэр
Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)	3 гишүүнтэй, нэг нь хараат бус. 2026 оны хагас жилд 4 удаа хуралдаж, 14 асуудал хэлэлцэж, 10 тогтоол гаргасан.	Г.Батжаргал (дарга), С.Пүрэвсүрэн, Ё.Амарбат (хараат бус)
Хөрөнгө оруулалтын хороо	Дотоод ажилтан, мэргэжлийн болон хараат бус этгээдээс бүрдэж, сангуудын хөрөнгө оруулалттай холбоотой стратегийн шийдвэр гаргана. Хөрөнгө оруулалтын бодлого, шийдвэр хөндлөнгийн хяналттай, ил тод, хараат бус байх нөхцөлийг хангана.	ТУЗ-ийн 2026.03.03-ны 02/26 тогтоол

Нэгж	Чиг үүрэг	Бүрэлдэхүүн, үндэслэл
Хөрөнгө удирдлагын газар	Үндсэн бизнес: шинэ сангийн судалгаа, бүтэц, загвар, дүрэм боловсруулах, сан байгуулах процесс; хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ; сангуудын гүйцэтгэл, зах зээлийн шинжилгээ.	Газрын захирал; хөрөнгө оруулалтын шинжээчид; БОНЗ хариуцсан мэргэжилтэн
Үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлагын газар	Хүний нөөц, албан хэрэг, санхүү, дотоод хэм хэмжээний акт, хууль зүйн зөвлөмж, өдөр тутмын үйл ажиллагааны дэмжлэг; Компани болон ХОС-д учирч болох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хариу арга хэмжээ төлөвлөх.	Хуульч; хүний нөөц, худалдан авах ажиллагааны мэргэжилтэн; ерөнхий нягтлан бодогч; сан хариуцсан нягтлан бодогч
Дотоод аудит, комплайнс	ТУЗ-д шууд хамаарах хяналтын чиг үүрэг: дотоод аудит (хараат бус баталгаа, зөвлөх үйлчилгээ), комплайнс (хууль, журмын нийцлийн хяналт).	Аудит, эрсдэлийн хороонд тайлагнана (4.3)

ХЭСЭГ 03

3. Тогтвортой хөгжлийн стратеги

Компанийн бизнесийн загвар нь Монгол Улсын төр, хөгжлийн байгууллагуудын санхүүжилтийг Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй хувийн сангуудаар дамжуулан орлогод нийцсэн орон сууц, ногоон санхүүжилт, хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээнд чиглэсэн хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэхэд чиглэдэг. Иймд ХОМК-ийн БОНЗ-ын гол нөлөө нь сангуудаар дамжуулан бий болгох санхүүжилтийн нөлөө, түүнийг хариуцлагатай удирдах тасралтгүй үйл ажиллагаанаас хамаарна.

3.1 Тогтвортой хөгжлийн зорилт ба төрийн бодлоготой уялдуулалт

Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан



3Г-ЫН 2024–2028 ОНЫ ХӨТӨЛБӨР

1.1.3.1 (дэд төвийн 20,000 айлыг орон сууцжуулах); 2.4.1.1, 2.4.1.2 (орлогод нийцсэн орон сууц, ипотек); 2.4.2.1 (эрчим хүчний хэмнэлттэй ногоон барилга); 3.4.3.7 (тогтвортой ногоон хот)

NDC 2030

Барилгын салбарт 830 мянган тонн CO2-д дүйцэхүйц бууралт

Ди Би Эм ногоон хөгжил



3Г-ЫН 2024–2028 ОНЫ ХӨТӨЛБӨР

3.4.2.1 (хүлэмжийн хийн тайлагнал, нүүрстөрөгчийн кредит, ногоон санхүүжилт); 3.4.3.2 (ногоон хөгжлийн загвар)

NDC 2030

Парисын хэлэлцээрийн NDC-ийн санхүүжилтийн тогтолцоо

Бүсийн ногоон хүртээмжтэй хөдөө аж ахуйн бизнес



3Г-ЫН 2024–2028 ОНЫ ХӨТӨЛБӨР

3.4.2.3 (хөдөө аж ахуйн салбарт байгальд ээлтэй технологи, нөхөн сэргээлт); бүсийн хөгжлийн бодлого

NDC 2030

Хөдөө аж ахуйн салбарт 5.28 сая тонн CO2-д дүйцэхүйц бууралт

Эх сурвалж: Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт (NCD) 2030-той холбоотой зааltууд.

3.2 Тайлант оны гол чиглэл, үр дүн

- Санхүүжилтийн татан төвлөрүүлэлт: 2 санд эхний санхүүжилтийг татаж, 1 санд санхүүжилт татах үйл явц үргэлжилж байна.
- Хамтран ажиллах банкуудыг сонгох: нийт 5 арилжааны банктай хамтран ажиллах гэрээ байгуулсан.
- Уур амьсгалын ногоон сангийн итгэмжлэгдсэн байгууллага болох зорилт: УАНС-ийн Зүүн болон Өмнөд Азийн бүсийн хуралд оролцож, УАНС болон бүс нутгийн түнштэй харилцаа тогтоосон ба УАНС-ийн Монгол дахь төлөөний газарт хүсэлтээ хүргүүлсэн.
- Олон нийтэд сурталчлах: НҮБ-ын COP17 (2026.08.24) хуралд оролцож, холбогдох арга хэмжээнүүдийг зохион байгуулсан, Төрийн болон хувийн хэвшлийн бусад байгууллагуудтай тогтмол хамтран ажилласан.

3.3 Ач холбогдолтой сэдвийн үнэлгээ

БОНЗ-ийн тайланд аль сэдвийг тусгахаа тодорхойлохдоо давхар ач холбогдлын хандлагыг баримталсан. Компани, сангуудын үйл ажиллагаа хүн, байгаль орчинд үзүүлэх нөлөө (нөлөөллийн ач холбогдол), мөн БОНЗ-ийн хүчин зүйлс Компани, сангийн санхүүгийн гүйцэтгэлд нөлөөлөх байдал (санхүүгийн ач холбогдол) гэсэн хоёр өнцгөөс үнэлсэн.

НӨЛӨӨЛЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ
Компани, сангуудын бий болгож буй нөлөө

+

САНХҮҮГИЙН АЧ ХОЛБОГДОЛ
Компанид учрах санхүүгийн эрсдэл, боломж

=

ДАВХАР АЧ ХОЛБОГДОЛ
Тайланд тусгах БОНЗ-ийн гол сэдвүүд

Тулгуур	Тодорхойлсон эрсдэл ба боломж	Ач холбогдолтой сэдэв
Ногоон хөрөнгө оруулалт ба уур амьсгал	**Эрсдэл** • Санхүүжилт татах хугацаа удаашрах • АХБ, УАНС-н шалгуурыг хангахгүй байх • Валют, хөрвөх чадварын **Боломж** • УАНС-ийн итгэмжлэл • Тогтвортой санхүүжилтийн 8 зарчмыг нэвтрүүлэх • Оролцогч талуудын хамтын ажиллагаа, мэдээллийн ил тод байдал	Ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалтын нөлөө Уур амьсгал, хүлэмжийн хийн ялгарал
Засаглал ба комплайнс	**Эрсдэл** • СЗХ-ны үүрэг даалгавар; • Аудитын зөвлөмжийн хэрэгжилт **Боломж** • Кодексийн хэрэгжилт 93.1% • Мөнгө угаахтай тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр батлагдсан	Засаглал, ёс зүй, комплайнс Эрсдэлийн удирдлага, аудит
Хүмүүс ба ажлын орчин	**Эрсдэл** • Хүний нөөцийн эргэц 39% • Орон тооны хязгаарт нийцүүлэн, ур чадвартай мэргэжилтнийг татах, хадгалах **Боломж** • Microsoft 365 нэвтрүүлсэн • Ажилчдын ажиллах орчин, нөхцөл сайжирсан • Сургалт, мэргэшүүлэх хөтөлбөрт хамруулах	Ажилтныг татах, хадгалах Сургалт, хөгжил
Нийгмийн хүртээмж	**Эрсдэл** • Үндсэн ажилтны жендерийн харьцаа 82% (эмэгтэй) **Боломж** • Удирдах албан тушаалтны жендерийн харьцаа 50%	Жендэр ба хүртээмж Жендерийн бодлого, дэмжлэг
Түншлэл ба оролцогч талууд	**Эрсдэл** • Түнш банкуудын оролцоо хангагдахгүй байх • Гуравдагч этгээдээс хамаарах гэрээний нөхцөл **Боломж** • АХБ, УАНС, МУХБ, ЭЗХЯ, МИК-тэй хамтын ажиллагаа	Оролцогч талуудын оролцоо, түншлэл
Оффисын орчин	**Эрсдэл** • Эрчим хүч, цаас, хог хаягдлын хэмжилт дутмаг **Боломж** • Ангилан цуглуулалт; • Дахин боловсруулалт	Эрчим хүч, хог хаягдал

хэсэг 04

4. Засаглал

4.1 Засаглалын бүтэц

Хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг Монголын Хөгжлийн банк (МУХБ)-ны Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлдэг (МУХБ-ны ТУЗ-ийн 2025.11.24-ний 37-р тогтоол). Компани нь Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн шийдвэрээр үйл ажиллагаагаа чиглүүлдэг бөгөөд ТУЗ нь мэргэжлийн үйл ажиллагааны стандарт, дүрэм, мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөр зэрэг үндсэн журмуудыг тогтоолоор батлан гаргадаг. Сан бүр тусдаа нэгж эрх эзэмшигч, өөрийн дүрэм, багц журамтай бөгөөд СЗХ-нд бүртгэлтэй, хөрөнгийг кастодиан банкинд хадгалуулдаг.

Төлөөлөн удирдах зөвлөл

ТУЗ нь 3 гишүүнтэй бөгөөд Компанийн дүрмийн дагуу нэг нь хараат бус гишүүн байна. 2026.03.27-ны ХЭХ-аар ердийн гишүүн Б.Төгсбаяр, Д.Болормаа нарыг чөлөөлж, Г.Батжаргал, С.Пүрэвсүрэн нарыг томилсон; Г.Батжаргалыг ТУЗ-ийн 2026.03.31-ний 01/26 тогтоолоор даргаар сонгосон. Хараат бус гишүүнийг «Нэр дэвшүүлэх түр комисс» сонгон шалгаруулж, СЗХ-ны 2026.04.24-ний 5/454 тоот «тохиромжтой этгээд» гэсэн тодорхойлолтын дагуу 2026.05.22-ны ХЭХ-ын 26/04 шийдвэрээр томилсон.

Г.Батжаргал
ТУЗ-ийн дарга
МУХБ-ны Актив, пассив хөрөнгийн удирдлагын газрын захирал
ХЭХ 2026.03.27 (26/02); дарга — ТУЗ 2026.03.31 (01/26)

С.Пүрэвсүрэн
ТУЗ-ийн гишүүн
Эдийн засаг, хөгжлийн яамны Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга
ХЭХ 2026.03.27 (26/02)

Ё.Амарбат
Хараат бус гишүүн
«Стоклаб секьюритиз» ҮЦК ХХК-ийн Гүйцэтгэх захирал
ХЭХ 2026.05.22 (26/04); СЗХ 2026.04.24 (5/454)

4	14 · 10	1 / 3	4
ТУЗ-ийн хурал (2026 оны хагас жил)	хэлэлцсэн асуудал · гаргасан тогтоол	хараат бус гишүүн (33.3%)	ХЭХ-ын шийдвэр (ээлжит 1, ээлжит бус 2 хурал)

ТУЗ-ийн гишүүдийн 33.3% нь эмэгтэй (3 гишүүнээс 1). ТУЗ-ийн дэргэд 2026 оны бүтцээр шинээр Хөрөнгө оруулалтын хороо байгуулахаар баталсан. Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх байнгын хороо байхгүй; хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг тухай бүр «Нэр дэвшүүлэх түр комисс» хэрэгжүүлсэн.

Мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөрийн дагуу ТУЗ нь Комплайнсын чиг үүрэг хариуцсан ажилтан болон Дотоод хяналт хариуцсан ажилтныг томилж, тэд хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад жилд 1-ээс доошгүй удаа тайлагнадаг. Хөтөлбөр 2026.09.21-ний №14/26 тогтоолоор батлагдсан.


4.2 Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт

Компани СЗХ-ны 2022 онд баталсан «Компанийн засаглалын кодекс»-ийн хэрэгжилтийг ханган ажилладаг. СЗХ 2025 оны жилийн эцсийн үнэлгээгээр кодексийн хэрэгжилтийг 9 зарчмын 36 заалтаар үнэлсэн (хянан баталгаажилт 2026.04): 31 заалт «2», 5 заалт «1» үнэлгээтэй. Хэрэгжилт 93.1% (67 / 72 оноо) бөгөөд хөрөнгө оруулалтын менежментийн 35 компанийн дунд 3-р байрт жагссан. «1» үнэлгээтэй заалтад үүрэг даалгавар өгсөн.

93.1%
Кодексийн хэрэгжилт (2025 жилийн эцсийн үнэлгээ)

3 / 35
ХОМК-ийн дундах байр

2026.06.08
СЗХ-ны зөвлөмж, үүрэг даалгавар өгсөн огноо



Зураг 2. Засаглалын кодексийн зарчим тус бүрийн заалтын үнэлгээ. Эх сурвалж: ХЗХ-ны хянан баталгаажилт, 2026.04.

Зарчим	СЗХ-ны үүрэг даалгавар	Компанийн хэрэгжүүлж буй арга хэмжээ
1-р зарчим: ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	ТУЗ-ийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ; 2026 оны сургалтын төлөвлөгөө	ТУЗ-ийн журмын төслийг боловсруулж ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн Засаглалын кодексын сургалтад 2026.04-д хамрагдсан (ХУГ-ын захирал, мэргэжилтэн)
2-р зарчим: ТУЗ-ийн дэргэдэх хороод	ТУЗ-ийн журмын шинэчилсэн төсөл; хороодын 2025 оны тайлан	Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүдийн хооронд байгуулах төлөөллийн гэрээний төслийг боловсруулсан Хөрөнгө оруулалтын хороо байгуулахаар бүтцэд тусгасан
Тайлагнал	Үйл ажиллагааны тайланд БОНЗ-ийн агуулгыг тусгах; засаглалын баримт бичиг, дүрэм, журамд өөрчлөлт оруулах	Энэхүү БОНЗ-ийн тайлан Хэрэгжүүлэх арга хэмжээг 2026 оны төлөвлөгөөнд тусгасан; оны эцэст нотлох баримтын хамт СЗХ-д хүргүүлнэ

4.3 Ёс зүй, комплайнс, эрсдэл

Компанийн үйл ажиллагааны эрсдэлийг гурван шатаар удирддаг: удирдлагын хяналт (дотоод хяналт), комплайнс, дотоод аудит. Хөндлөнгийн үнэлгээг Үндэсний аудитын газар болон Эрнст энд Янг Монголия Аудит ХХК гүйцэтгэсэн.

Хамгаалалтын шугам	Тайлант хугацаанд хийсэн ажил	Төлөв
1. Удирдлагын хяналт Дотоод хяналт	• Гүйцэтгэх захирлын тушаал, ТУЗ-ийн тогтоолын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьсан • Үйл ажиллагааны зардлын төсвийн гүйцэтгэлийг хянасан	Үйл ажиллагаа явуулж байна
2. Комплайнс	• СЗХ-д кодексийн хэрэгжилтийн тайлан, нотлох баримт; МС-4 маягтын тайлан (хүний нөөц, санхүү, ХОС-ын мэдээлэл) илгээсэн • Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний тайлан илгээсэн • ХЭХ, ТУЗ-ийн шийдвэрийн төслийн нийцлийг тухай бүр хянаж зөвлөсөн	Тайлан, мэдээллийг хугацаанд нь хүргүүлсэн
3. Дотоод аудит	• Аудит, эрсдэлийн хорооны 2025.01.10-ны төлөвлөгөөний дагуу 2025 оны жилийн эцсийн байдлаарх стратеги, бизнес төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл, зөвлөмжийн биелэлтийг шалгаж «АТ-2025-07» тайланг ТУЗ-д танилцуулсан • МУХБ-ны Дотоод аудитын газрын зөвлөмжийн дагуу «Дотоод аудитын дүрэм», «Дотоод аудитын үйл ажиллагааны журам»-ыг ДАМПОУС-д нийцүүлэн боловсруулж ТУЗ-д танилцуулсан • 2026 оны төлөвлөгөө «АТ-2026-01»-ийн хүрээнд ХЭХ-ын үүрэг даалгавар, кодексийн хэрэгжилт, ХОС-уудын үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэлд аудит хийж байна	Журмыг батлуулахаар ажиллаж байна
Хөндлөнгийн аудит УАГ, Эрнст энд Янг	• Үндэсний аудитын газар, Эрнст энд Янг Монголия Аудит ХХК 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон засаглал, эрсдэл, хяналтын тогтолцооны гүйцэтгэлийн аудит хийсэн	Төлөвлөгөөний биелэлтийг хангаж байна

Мэргэжлийн үйл ажиллагааны стандарт болон ажилтны ёс зүйн дүрмийг ТУЗ 2026 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн №04/26 тогтоолоор шинэчлэн батлаж, 2018 оны №36/18 дүрмийг хүчингүй болгосон. Дүрэм нь компанийн бүх албан тушаалтан, ажилтанд үйлчилнэ. Гол агуулга:

- Хууль тогтоомжийг дагаж мөрдөх; хүний эрх, нэр хүндийг хүндэтгэх; үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, шашин шүтлэг, нийгмийн гарал, хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхахгүй байх (3.4–3.5).
- Албан тушаалын байдлаа ашиглан бусдыг дарамтлах, хүчирхийлэх, дороомжлохыг хориглох (3.16–3.19).
- Авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх; бэлэг, үйлчилгээ, давуу байдал хүлээн авахыг хязгаарлах (3.9, 3.14).
- Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; зөрчил үүссэн тохиолдолд мэдэгдэх (3.11, 4.6); харилцагч, хөрөнгө оруулагчийн өмнөх шударга, нууцлалтай байх үүрэг (4.3–4.4, 3.20).
- Улс төрийн нам, хөдөлгөөнд ажлын байрны нөлөөгөөр оролцохгүй байх (3.10).

Ёс зүйн хороо: ТУЗ-өөс томилогдсон 3 гишүүнтэй байнгын орон тооны бус хороо ажиллана (дүрэм 5.1–5.3). Хорооны ажиллах журмыг Гүйцэтгэх захирлын 2019.08.12-ны А-30 тушаалаар баталсан. Гомдол,

мэдээллийг компанийн цахим шуудан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ирсэн тохиолдолд хүлээн авч, буцах нэр, хаяг тодорхойгүй гомдлыг шалгахгүй. Гомдлыг 14 хоногт шалгаж (шаардлагатай бол 7 хоногоор нэг удаа сунгана), хуралдаанд хэлэлцээд дүгнэлтийг 3 хоногийн дотор албажуулна. Гомдол гаргасан ажилтныг шахаж дарамтлахыг хориглосон; гомдлыг шалгах ажиллагааны мэдээллийн нууцыг хадгалдаг (дүрэм 6.2–6.4).

Комплайнс: Комплайнсын журмыг (Гүйцэтгэх захирлын 2019.03.21-ний А-11 тушаал) баталж, Комплайнс хариуцсан ажилтан жилийн төлөвлөгөө гарган гүйцэтгэлээ ТУЗ-д тайлагнахаар заасан.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

ТУЗ-ийн 2026.09.21-ний №14/26 тогтоолоор батлагдсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр (хувилбар 1.0) нь 2017.11.01-ний №05/17 журмыг орлосон. Гол чиглэл:

- Харилцагч таньж мэдэх: харилцагчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох, эрсдэлийг 3 түвшнээр (бага, дунд, өндөр) үнэлэх; өндөр эрсдэлтэй ангиллын харилцагчтай бизнесийн харилцаа тогтоохоос татгалзах, нарийвчилсан шалгалт хийх (хөтөлбөр 4–5-р бүлэг).
- Мэдээлэл өгөх: 20 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээг 5 ажлын өдрийн дотор, сэжигтэй гүйлгээг 24 цагийн дотор Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ (6-р бүлэг).
- Шинэ технологи, бүтээгдэхүүний эрсдэлийн үнэлгээ; Комплайнсын ажилтны сургалт жилд 1-ээс доошгүй удаа (7-р бүлэг).
- Мэдээллийн нууцлал, мэдээлэл өгсөн ажилтныг дарамтлахыг хориглох; харилцагчийн хувийн хэрэг, гүйлгээний баримтыг бизнесийн харилцаа дууссанаас хойш 5-аас доошгүй жил хадгалах (8-р бүлэг).
- Хэрэгжилтийн хяналт: Дотоод хяналтын ажилтан бие даасан шалгалт хийж, Комплайнсын ажилтан хөтөлбөрийн үр дүнг ТУЗ, Гүйцэтгэх удирдлагад жилд 1-ээс доошгүй удаа танилцуулна (9-р бүлэг).

Тайлант хугацаанд ёс зүйн зөрчлийн гомдол, сэжигтэй гүйлгээний Мэдээлэл байхгүй. Компанийн комплайнсын ажилтан нийт ажилтнуудыг батлагдсан хөтөлбөрийн талаар сургалтанд хамруулсан.

- Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, БОНЗ, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийг үнэлж мэдээлэх заалт (кодекс 5.1–5.4, ХЗХ-ны хянан баталгаажилт);
- Цахим хуудас www.dbmamc.mn-ээр дамжуулан оролцогч талуудтай харилцдаг (кодекс 7.3, 9.1).

Хөрөнгө оруулалтын сангуудын цаашид анхаарах эрсдэлүүд

Валютын ханшийн эрсдэл	Санхүүжилтийн хөрөнгө ам.долларааар байршиж байгаа үед цэвэр хөрөнгийн үнэлгээг төгрөгөөр тооцдог. Төгрөг чангарахад ашигт сөргөөр нөлөөлнө; хөрвүүлэлтийг хөрөнгө оруулалтын хугацаа, ханшийн төлөвтэй уялдуулан төлөвлөнө.
Хөрвөх чадварын эрсдэл	Хугацаатай хадгаламжийг хугацаанаас нь өмнө цуцлахад хүүгийн орлого алдах эрсдэлтэй; хугацааг төсөлд хийх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдуулан удирдана.
Хөрөнгө оруулалт хэрэгжих хугацааны эрсдэл	Ногоон төслүүдэд хөрөнгө оруулалт хойшлох тохиолдолд сангийн зорилго хэрэгжилт удаашрах эрсдэлтэй; ХОМК оролцогч талуудтай хамтран бэлтгэл ажлыг шуурхай явуулна.

4.4 Санхүүгийн удирдлагыг сайжруулах төлөвлөгөө

Азийн хөгжлийн банк 2024 оны 11 дүгээр сараас 2025 оны 1 дүгээр сарын хооронд ХОМК-ийн санхүүгийн удирдлагын үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн. Үнэлгээнд тулгуурлан «Компанийн санхүүгийн удирдлагыг сайжруулах төлөвлөгөө»-г Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан бөгөөд гүйцэтгэл 2026

оны гуравдугаар улирлын байдлаар хэрэгжилт 96% байна. Цаашид төлөвлөгөөг шинэчлэн баталж, хэрэгжилтийг АХБ-нд тогтмол тайлагнах шаардлагатай.

Чиглэл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл
Хүний нөөц	АХБ-ны төслийн санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх 1 санхүүгийн мэргэжилтэн нэмж авах; сургалтанд хамруулах.	✓ 1 санхүүгийн шинжээч ажилд авсан; III улиралд эрсдэлийн шинжээч, худалдан авалтын мэргэжилтний шинээр авсан; нягтлан, санхүүгийн мэргэжилтэн сургалтад хамрагдсан.
Төлөвлөлт, төсөвлөлт	Төслийн төсвийг СЯ-ны саналаар баталгаажуулах; санхүүгийн загварыг шинэчлэх.	✓ Загварыг шинэчилж АХБ-д хугацаанд нь хүргүүлсэн.
Нягтлан бодох бүртгэл	Төслийн санхүүгийн тайлангийн иж бүрэн төлөвлөгөө, загвар.	✓ Сангийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн эхний төсөл бэлэн болсон.
Дотоод хяналт, аудит	Бодлого, журмыг хянах; 2024 оны дотоод аудитын тайланг АХБ-д ирүүлэх.	✓ Нийцлийн дүгнэлт гарган хугацаанд нь хүргүүлсэн; 2024 оны зарим хэсгийн дотоод аудитын тайланг хүргүүлсэн. 2025, 2026 онд санд тухайлсан дотоод хяналтын дүгнэлт гараагүй
Хөндлөнгийн аудит	Санхүүжилтийн зарцуулалтын эхний тайланг хойшлуулах хүсэлт илгээх;	✓ Хүсэлтийг АХБ-д хүргүүлж баталгаажуулсан;
Мэдээллийн систем	Сангийн мэдээллийн системийг шинэчлэх.	✓ Зөвлөх үйлчилгээний хүрээнд хийгдэхээр төлөвлөгдөж байна.

✓

96%

төлөвлөгөөний гүйцэтгэл (2026 оны III улирал)

4.5 Баримт бичгийн тогтолцоо

1. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр — ТУЗ, №14/26, 2026.09.21 *Хүчинтэй (хувилбар 1.0); №05/17-г хүчингүй болгосон*
2. Мэргэжлийн үйл ажиллагааны стандарт болон ажилтны ёс зүйн дүрэм — ТУЗ, №04/26, 2026.03.03 *Хүчинтэй; №36/18-г хүчингүй болгосон*
3. Ёс зүйн хорооны ажиллах журам — Гүйцэтгэх захирал, А-30, 2019.08.12 *Хорооны бүрэлдэхүүнийг шинэчилсэн эсэхийг баталгаажуулна*
4. Комплайнсын журам, хангах ажлын төлөвлөгөө — Гүйцэтгэх захирал, А-11, 2019.03.21 *Хүчинтэй эсэхийг баталгаажуулна*

5	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод журам — ТУЗ, №05/17, 2017.11.01 *Хүчингүй болсон (№14/26-аар)*
6	Мэргэжлийн үйл ажиллагааны болон ажилтны ёс зүйн дүрэм (өмнөх) — ТУЗ, №36/18, 2018.10.24 *Хүчингүй болсон (№04/26-аар)*

ЭХОНОС сангийн төслийн удирдлага, санхүүгийн үйл ажиллагааг дэмжих 20 төрлийн баримт бичигтэй (санхүүжилтийн гэрээ, хөгжүүлэгчийг сонгох шалгуур, хамтран ажиллах банкид тавих шаардлага, гомдол барагдуулах механизм, нийгэм-жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, байгаль орчны удирдлагын төлөвлөгөө г.м).

БНХХААБ сан 2026 онд 38 баримт бичгийг шинэчилж, шинээр боловсруулсан бөгөөд үүнээс 13 нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон холбогдох журмаар заавал байх баримт, 25 нь АХБ болон олон улсын хөгжлийн санхүүжилтийн байгууллагын шаардлагад нийцүүлэх нэмэлт баримт юм.

13	Хуулиар заавал байх үндсэн баримт бичиг — сангийн дүрэм, хөрөнгө оруулалтын бодлого, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, нэгж эрхийн үнэ тогтоох журам
4	Засаглал, оролцогч талуудын харилцаа — ТУЗ-ийн журам, гарын авлага, оролцогч талуудын оролцоо, мэдээллийн ил тод байдал
8	Санхүүгийн механизм, санхүүжилтийн хэрэгсэл — санхүүжилтийн журам, үнэлгээний аргачлал, батлан даалтын журам, ногоон инновацын нөхцөлийн тэтгэлэг
4	Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн хяналт — бодлого, журам; аудитын хуудас; ашиг алдагдлын загвар; тайлангийн маягт
4	Байгаль орчин, нийгмийн удирдлага — ESMF; байгаль орчин, нийгмийн шалгуур; гомдол барагдуулах механизм; сургалтын материал
5	Үйл ажиллагааны бэлэн байдал, ажлын хэрэгцээ — бэлэн байдлыг шалгах хуудас; түнш банкийг сонгох үнэлгээний аргачлал; хамтарсан санхүүжилт татах стратеги

хэсэг 05

5. Байгаль орчин

5.1 Оффисын үйл ажиллагааны нөлөөлөл

Компанийн үйл ажиллагаа оффист суурилдаг тул шууд байгаль орчны нөлөө бага боловч эрчим хүч, цаас, ажлын орчны үр ашгийг тогтмол хянах шаардлагатай. Тайлант онд 2 өрөөнд ажилласан бөгөөд хоёр тоолуурын заалтаар хэрэглээг тооцов.


Цахилгааны хэрэглээ

4,223 кВт·ц
нийт хэрэглээ, 1–9 сар

1,657,000 ₮
нийт төлбөр (НӨАТ-тай)

3,529.1 кВт·ц
2305 тоот · 83.6% · 1,386,915 ₮

693.9 кВт·ц
2303 тоот · 16.4% · 270,085 ₮




Зураг 3. 2303, 2305 тоотын сарын цахилгааны хэрэглээ, кВт·ц (коэффициент 1.025-ыг оруулсан). Эх сурвалж: цахилгааны төлбөрийн тооцооны хуудас. Хэрэглээ = заалтын зөрүү × 1.025;

Гол ажиглалт:

- Хоёр өрөөний нийт хэрэглээ 4,223 кВт·ц (4.22 МВт·ц), үүний 83.6% нь 2305 тоотод ногдсон. Нэг кВт·ц-д ногдох бодит дундаж зардал ойролцоогоор 392 төгрөг (чадлын төлбөр, НӨАТ-тай).
- Хамгийн их хэрэглээ 1 дүгээр сард (671 кВт·ц), хамгийн бага нь 7 дугаар сард (313 кВт·ц) байна.
- 6 дугаар сараас цахилгааны тариф 265-аас 280 төгрөг/кВт·ц болж 5.7%-иар өссөн.
- Тайлант хугацааны эхний 9 сарын хугацаанд оффисын цахилгаан эрчим хүчний хэрэглээнээс нийт 3.2 tCO_2e (4.223 МВт·ц × 0.753 tCO2/МВт·ц ≈ 3.18 tCO2e) хүлэмжийн хий ялгарсан. Энэ нь хотын орчинд тарьсан 53 орчим мод 10 жилийн хугацаанд шингээх нүүрстөрөгчийн давхар ислийн хэмжээтэй дүйцэхүйц үзүүлэлт юм. Цаашид эрчим хүчний хэрэглээг бууруулах, байгаль орчны нөлөөллийг тогтмол хянах шаардлагыг онцолж байна.

Нөөцийн үр ашгийн арга хэмжээ

- 2026 онд оффисоо шинэчилж, нэг ажилтанд ногдох талбайн хэмжээг томруулж, ажлын байрны орчин, ажиллах нөхцөлийг сайжруулсан.
- Оффисын өдөр тутмын үйл ажиллагаанд нэг талаа ашигласан цаасыг ноорог болгон дахин ашигладаг.
- Ажилтнууд 07:30–09:00 цагийн хооронд ирж, 16:30–18:00 цагийн хооронд тардаг уян хатан цагийн систем мөрддөг.
- Хог хаягдлыг ангилан цуглуулах: оффисын B1 давхарт байрлах хогийн сав 4 ангилалтай — шил, лааз; цаас; хуванцар, гялгар уут; бусад (дахин боловсруулах боломжгүй) хог.



Зураг 4. Оффисын B1 давхарт байрлах 4 ангилалтай хогийн сав (шил, лааз · цаас · бусад хог · хуванцар).

Оффисын байгаль орчны үр нөлөөг бууруулах арга хэмжээ

Чиглэл	Арга хэмжээ	Хүлээгдэх үр дүн / хэмжих үзүүлэлт
Цахилгаан	• Гэрэлтүүлгийг LED, хөдөлгөөн мэдрэгчтэй болгох; ашиглаагүй хэсгийн гэрэл, цахилгааныг салгах. • Ажилтан бүрийн компьютер, хэвлэгч, ус халаагчийг ажил тарахад унтраадаг дүрэм бий болгох. • Агааржуулалт, халаалтыг ажилтны ирцтэй уялдуулах.	жилд ойролцоогоор 560 кВт·ц, ≈ 0.4 тCO2e (коэффициент 0.753), 150–220 мянган ₮-ийн зардал хэмнэгдэнэ.
Цаас, хэвлэмэл	• Хоёр талаар хэвлэх, дэлгэцээр хянах, цахим гарын үсэг, цахим баримт бичгийн урсгал бий болгох. • Ашигласан цаасыг дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлдэг болох.	Сарын цаасны хэрэглээ (хуудас/кг), дахин боловсруулахад өгсөн хэмжээ.
Хог хаягдал, хэрэглээ	• Цаас, хуванцар, шилийг ялгаж цуглуулах; нэг удаагийн аяга, сав, хоолны хэрэгслийг ашиглахгүй байх. • Хэвлэгчийн хор, батарей, цахилгаан хэрэгслийг хүлээлгэн өгөх тогтсон хаягтай болох.	Сард цуглуулсан цаас, хуванцарын кг; дахин боловсруулахад өгсөн хувь.
Ус	• Одоогоор оффисын ус, дулааны төлбөр тухайлсан өрөөний хэрэглээгээр тооцогддоггүй тул нэг хүнд ногдох дундаж хэрэглээнд суурилан төлбөр төлдөг болох хүсэлтийг оффисын ашиглалт хариуцсан газарт гаргах.	Ингэснээр усны хэрэглээ илүү хэмжигдэхүйц болно (м³/ажилтан).
Ажилтны зорчилт	• Уян хатан цагтай тул түгжрэлээс зайлсхийх боломжтой; нийтийн тээвэр, дугуй, нэг чиглэлийн ажилтнуудын хамтарсан зорчилтыг дэмжих. • Ажилтнуудын цахимаар ажиллах боломж, нөхцөлийг судалж хэрэгжүүлэх.	Ажилтан тус бүрийн зорчилтын нэг удаагийн судалгаагаар (хэрхэн ирдэг, хэдэн км) ойролцоо тооцоогоор үр дүнг тооцох боломж бүрдэнэ.
Ажилтны оролцоо, зан үйл	• Жилд 1–2 удаа «ногоон» сургалтанд хамрагдаж, сарын цахилгаан, цаасны хэмнэлтийн мэдээлэл, хог хаягдлын зааварчилгааг ажилтанд танилцуулах. • Ажилтнууд мод тарих эсвэл бусад байгаль орчинд хувь нэмэр оруулах үйл ажиллагаанд тогтмол хамрагддаг байх.	Сургалтын тоо, оролцсон ажилтан; мод тарих үйл ажиллагааны тоо, тарьсан мод.

5.2 Сангуудын байгаль орчин, уур амьсгалын нөлөө

Сан бүрийн зорилго, нөлөөллийн логик болон 2026 оны явцыг доор харуулав. Мөнгөн дүнг ам.долларааар, төсөл хөтөлбөрийн хэмжээг төлөвлөсөн үзүүлэлтээр илэрхийлэв.

Сан	Зорилго, нөлөөллийн логик	2026 оны явц
Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл (ОНОСХШТ)-ийг АХБ, НЗДТГ-тай хамтран хэрэгжүүлнэ. • Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, стандарт хангахгүй гэр хорооллын 54 га талбайг дахин төлөвлөнө • Ойролцоогоор 4,200 айлын орлогод нийцсэн эко орон сууц • Хөгжүүлэгч, банкны оролцоо нь EDGE зэрэг эрчим хүчний үр ашигтай барилгын стандартыг дэмжинэ	✓ 2026.02.25: Төслийн удирдах хороо үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан ✓ Сангийн яам 4.15 сая $ хүсэлтийг 06.10-нд баталсан. 08.13-нд АХБ-д хүргүүлж, 08.21-нд АХБ баталгаажуулсан ✓ 6 банк сонирхол илэрхийлж 2026.03-д санамж бичиг байгуулсан; Үнэлгээний хороо (11 гишүүн, НЗДТГ А/107, 04.15) ✓ МИК-тэй санамж бичиг (06.08): ипотекийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасаар санхүүжүүлэх Тайлант хугацаанд хөрөнгө оруулалт хийгдээгүй; бүрэлдэхүүн 2-ын газар чөлөөлөлт B12 талбарт эхэлсэн
Ди Би Эм ногоон хөгжил	Агаар, орчны бохирдлыг бууруулах, ногоон санхүүжилтийн тогтолцоо, цэвэр технологийг дэмжих. Салбар: ногоон барилга, эрчим хүчний хэмнэлт, усны менежмент, хөдөө аж ахуй, хог хаягдал. • МНСК-ийн 17,600,000 ширхэг хувьцаа эзэмших гэрээ байгуулсан («Си Жи Эф» ХХК, Уур амьсгалын ногоон сангийн хамт) • МНСК нь УАНС, Засгийн газар, хувийн хэвшлээс 50 сая $-ын эх үүсвэр баталсан; банк, санхүүгийн байгууллагад бөөний ногоон зээл олгоно	✓ 2026.06.29: хувьцаа захиалгын болон хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулсан; 5.0 сая $-тай тэнцэх хөрөнгө оруулалтыг МНСК-д шилжүүлэх үүрэгтэй ✓ Үндэсний ногоон лаб-тай хамтарч төслийн сан (pipeline) бүрдүүлж байна МНСК-ийн хувьцааг худалдан авах нэхэмжлэл хойшлогдсон тул 2026.09.30-ны байдлаар хөрөнгө оруулалт хэрэгжээгүй;
Бүсийн ногоон хүртээмжтэй хөдөө аж ахуйн бизнес сан	«Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр» 2023–2033 онд 17 аймгийн 52 суманд хэрэгжихээр төлөвлөгдсөн. Нийт 735.0 сая $: зээл 550, буцалтгүй 78.0, Засгийн газар 75.3, хувийн хэвшил, банк 31.7; эхний үе шат 270.0 сая $. • ХХЯ-ын цэвэр бууралт 117.4 сая тCO2e (GCF-ийн албан ёсны эх сурвалжид 112.4 — 5.3) • 11,400 шууд, 150,000 дам ажлын байр • Шууд үр өгөөж хүртэгч 552,300 хүн (54,000 орчим эмзэг малчин өрх); шууд бус 3.2 сая хүн • 28.8 сая га бэлчээрийн тогтвортой, нүүрстөрөгч багатай менежмент	✓ СЗХ-ны 2026.05.07-ны №149 тогтоолоор бүртгэгдэж, 05.21-нд УБЕГ-т бүртгүүлсэн ✓ Кастодианыг сонгон хөрөнгө хадгалах гэрээ байгуулсан; мэргэжлийн хувь зөвлөхүүд 2026.04.01-ээс ажиллаж эхэлсэн ✓ Түнш банкуудыг нарийвчилсан үнэлгээгээр сонгосон Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах бэлтгэл үргэлжилж байна

5.3 Сангуудаас хөрөнгө оруулалт хийх төслүүдийн нөлөө (AHURP, ASDIP, MGFC)

Компанийн удирдаж буй гурван сан нь Уур амьсгалын ногоон сангаас санхүүждэг гурван төсөл, хөтөлбөртэй холбогдон ажилладаг.

AHURP · FP077 Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл

Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан · Эрх бүхий байгууллага: Азийн хөгжлийн банк · УАНС зөвшөөрсөн 2018.03.01

145 сая $
GCF санхүүжилт (зээл 95 сая $ + буцалтгүй 50 сая $)

7.92 сая тCO2e
шууд бууралт, хугацааны турш (дам 39.59 сая)

5,000 өрх
15,000 хүн ногоон орон сууцтай болно; 5,000 орон сууц

Хамтран санхүүжилт	425.1 сая $; төслийн нийт өртөг 570 сая $
Хэрэгжих хугацаа	2018.12.18-аас; дуусах төлөв 2030.12.31
Шууд жилийн бууралт	204,410 тCO2e
Нийгмийн үр нөлөө	Шууд 100,000, шууд бус 900,000 хүн
Байгаль орчны нөлөө	Тухайн бүсийн орчны бохирдол 70%-иас дээш буурна; Улаанбаатарын 1.4 сая оршин суугч агаарын бохирдол багасна; халаалтын эрчим хүч 395-аас 151 кВт·ц/м²/жил; 11 МВт-аас дээш нарны цахилгаан станц (15.6 ГВт·ц/жил)
ESS ангилал	B

ASDIP · FP154 Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Бүсийн ХАА-н сан · Эрх бүхий байгууллага: Азийн хөгжлийн банк · УАНС зөвшөөрсөн 2021.03.19 (B.28)

175 сая $
GCF санхүүжилт (зээл 130 сая $+ буцалтгүй 45 сая $)

112.4 сая тCO2e
цэвэр бууралт (АХБ); GCF хуудсанд ≈112 сая

3.8 сая хүн
шууд 552,300; шууд бус 3.2 сая; 11,400 ногоон ажлын байр

Хамтран санхүүжилт	560 сая $; төслийн нийт өртөг 735 сая $
Хэрэгжих хугацаа	FAA 2025.01.23-аас; дуусах төлөв 2035.01.23 (АХБ-ны хөтөлбөр 2033 он гэж тэмдэглэсэн)
Нийгмийн үр нөлөө	150,000+ шууд бус ажлын байр
Байгаль орчны нөлөө	Монголын бэлчээрийн 70% нь доройтсон; бэлчээрийн 28.8 сая га-г нүүрстөрөгч багатай, тогтвортой менежментэнд хамруулна
ESS ангилал	B

MGFC · FP153 Монголын ногоон санхүүгийн корпораци

Ди Би Эм ногоон хөгжил сан · Эрх бүхий байгууллага: Хас банк (XacBank) · GCF зөвшөөрсөн 2020.11.13 (B.27)

26.65 сая $
GCF санхүүжилт (өмчийн оролцоо 4.65 сая $, буцалтгүй 2.0 сая $, зээл 15 + 5 сая $)

3.75 сая тCO2
бууралт, хугацааны турш (3,754,767)

86,291 хүн
шууд (43,145 эмэгтэй); шууд бус 1,491,375

Хамтран санхүүжилт	23 сая $; төслийн нийт өртөг ойролцоогоор 49.7 сая $
Хэрэгжих хугацаа	FAA 2026.07.23-аас; дуусах төлөв 2029.07.23
Байгаль орчны нөлөө	Амины орон сууцны дулаалга, бизнесийн эрчим хүчний хэмнэлт, ногоон орон сууцны ипотекийг түнш банкаар дамжуулан санхүүжүүлнэ
ESS ангилал	Intermediation 2 (зуучлагч)

хэсэг 06

6. Нийгэм

6.1 Ажилтан, ажлын орчин

Компанийн хүний нөөцийн бодлого гүйцэтгэлд суурилсан бөгөөд «Хүний нөөцийн бодлого», «Хөдөлмөрийн дотоод журам»-ыг мөрддөг. 2026 онд бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсантай холбоотойгоор албан тушаалын жагсаалт, тодорхойлолт, цалингийн сүлжээг шинэчилж, ажлын орчин, мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулсан.

19
ажилтан, (ТУЗ-ийн харьяа 2 + гэрээт 6)

15 · 10
орон тооны дээд хязгаар: үндсэн · гэрээт

39%
хүний нөөцийн эргэц (II улирал)

7
сургалт, мэргэшлийн арга хэмжээ (хагас жил)

Хүний нөөцийн удирдлага

Чиглэл	Хийсэн ажил	Төлөв
Бүтэц, орон тоо	• ТУЗ-ийн 2026.03.03-ны 01/26, 02/26 тогтоолоор төсөв, бүтэц, орон тоо (үндсэн 15, гэрээт 10) батлагдсан • Гүйцэтгэх захирлын 2026.03.17-ны А/05 тушаалаар «Албан тушаалын жагсаалт», А/06 тушаалаар «Албан тушаалын тодорхойлолт» шинэчлэгдсэн	✓ Хэрэгжиж байна
Бүрдүүлэлт	• Сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, эрсдэлийн шинжээч, худалдан авалтын мэргэжилтний ажлын байранд явуулсан (Засгийн газрын 2023 оны 86-р тогтоолын нийтлэг журам, Хүний нөөцийн бодлого, Хөдөлмөрийн дотоод журмын дагуу) • Баримт бүртгэх → шалгуур хянах → ярилцлага → Гүйцэтгэх захиралд танилцуулж шийдвэрлүүлэх	✓ Мөрдөж байна
Цалин, урамшуулал	• Гүйцэтгэлийн үнэлгээ, цалин урамшууллын оновчтой системийн хүрээнд Гүйцэтгэх захирлын 2026.03.30-ны А/09 тушаалаар үндсэн цалингийн сүлжээг шинэчлэн батлагдсан	✓ Мөрдөж байна
Ажлын орчин, мэдээллийн технологи	• Суурин, зөөврийн компьютер, принтер зэрэг техник хэрэгслийг шинэчилсэн • Microsoft 365 (Outlook, Teams, OneDrive, SharePoint, Word, Excel, PowerPoint)-д бүрэн шилжиж, баримт бичгийг цахим орчинд хадгалах, хамтран ажиллах, зайнаас ажиллах нөхцөл сайжирсан • 2026 онд оффисоо шинэчилж, нэг ажилтанд ногдох талбайг томруулсан; 07:30–09:00 цагт ирж 16:30–18:00 цагт тардаг уян хатан цагийн систем	✓ Ажлын байрны тав тух, мэдээллийн аюулгүй байдал, бүтээмж сайжирсан

Чиглэл	Хийсэн ажил	Төлөв
Тэгш байдал, дарамтгүй орчин	• Ёс зүйн дүрмийн 3.5, 3.16–3.19 (ялгаварлан гадуурхалт, дарамтыг хориглох); гомдлыг Ёс зүйн хороо шалгана (4.3) • Үндсэн ажилтны 81.8% нь эмэгтэй	✓ Дүрэм мөрдөгдөж байна; гомдлын тоо Мэдээлэл байхгүй
БОНЗ-ийн зохицуулалт	• БОНЗ-ын чиглэлээр 1 мэргэжилтэн 2026 оноос ажиллаж эхэлж, мэдээлэл цуглуулалт, тайлагналыг хариуцан ажиллаж байна	✓ Хөрөнгө удирдлагын газрын бүрэлдэхүүнд

Сургалт, мэргэшүүлэх арга хэмжээ (2026 оны хагас жил)

2026.04	Компанийн засаглалын сургалт (СЗХ-ны кодексын хэрэгжилт) — ХУГ-ын захирал, хүний нөөц, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн
2026.05	Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн сургалт (Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо) — Хөрөнгө оруулалтын шинжээч, амжилттай төгссөн
2026.06	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалт (Худалдан авах ажиллагааны газар) — Гүйцэтгэх захирал, БОНЗ хариуцсан мэргэжилтэн; А3-ын эрх авсан
2026.06.25	АХБ-ны хамгааллын бодлого: «Жендерийн тэгш эрх, эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх мэдэл — Хүртээмжтэй, тэгш хамруулсан нийгэм ба дэд бүтэц» — Хөрөнгө оруулалтын шинжээч, БОНЗ хариуцсан мэргэжилтэн
Хагас жил	Хөрөнгө оруулалтын шинжээч CFA Level II шалгалтад хамрагдсан; Хуульч СЭЗИС-ийн Санхүү, банк хөтөлбөрийг төгсөж бакалаврын зэрэг эзэмшсэн
Тайлант он	АХБ-ны зээлдэгчид зориулсан санхүүгийн удирдлагын сургалтад холбогдох ажилтнууд хамрагдсан


Ажилтны бүтэц, хүйсийн харьцаа

11
үндсэн ажилтан · 81.8% эмэгтэй

6
гэрээт ажилтан · 16.7% эмэгтэй

2
ТУЗ-ийн харьяа ажилтан · 100% эмэгтэй

3
ТУЗ-ийн гишүүн · 33.3% эмэгтэй



Зураг 5. Ажилтны ангилал тус бүрийн хүйсийн харьцаа (хаалтад хүний тоо)..

Үндсэн ажилтны 81.8% нь эмэгтэй, ТУЗ-ийн гишүүдийн 33.3% нь эмэгтэй байна. Гэрээт ажилтны дунд эрэгтэй давамгайлж (5/6), ТУЗ-ийн харьяа 2 ажилтан хоёулаа эмэгтэй байна. Гүйцэтгэх болон дунд, анхан шатны удирдлагын түвшний хүйсийн харьцаа, цалингийн зөрүүг тодорхойлоогүй.

6.2 ЭХОНОС сангийн жендэрийн төлөвлөгөө

Зорилт	Агуулга
7.1	Хүртээмжтэй, жендэрийн мэдрэмжтэй байдлыг хангасан зураг төслийн 20-иос доошгүй онцлогтой байхыг хөгжүүлэгчдээс шаардах.
7.2	Өрхийн санал хүсэлт авах хамгийн багадаа 2 хэлэлцүүлэг (50%-иас доошгүй эмэгтэйг хамруулан).
8.1–8.3	Эко хорооллын бизнес хөгжүүлэлт, сургалтын хэрэгцээний дүн шинжилгээ; 20 сургалт, 400+ оролцогч; бизнесийн 40% эмэгтэй удирдлагатай, 15% эмзэг бүлгээс байх.
9.1–9.2	Барилгын ажлын хүн-сарын 30% эмэгтэй; ижил цалин хөлсний заалт үйлчлэх.
10.1	Ногоон орон сууцны зээлд хамрагдах оршин суугчийн 25%-иас доошгүй эмэгтэй байх.
11.1	Хөгжүүлэгч, банкны удирдах албан тушаалтны 30%-иас доошгүй нь нөлөөллийн/жендэрийн хөрөнгө оруулалтын сургалтад оролцох.

Тус төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотойгоор 2026 онд нэг арга хэмжээг хэрэгжүүлсэн.





Зураг 6. Банк, оролцогч талуудад зориулсан нөлөөллийн хөрөнгө оруулалтын талаарх сургалт, хэлэлцүүлэг.

6.3 Оролцогч талуудтай харилцах

Компани нь хөгжлийн түнш, төрийн байгууллага, зохицуулагч, арилжааны банк, хөрөнгийн зах зээлийн болон тогтвортой санхүүжилтийн байгууллагуудтай хамтран ажилладаг. Доор тайлант хугацаанд харилцсан гол талуудыг харуулав.



Хамтрагч тал	Үүрэг	Тайлант оны хамтын ажиллагаа
Уур амьсгалын ногоон сан	Төслүүдийн санхүүжилт олгогч; Итгэмжлэгдсэн байгууллага болгох эрх олгох үнэлгээ хийх.	УАНС-ийн Зүүн болон Өмнөд Азийн бүсийн яриа хэлэлцээрт (Коломбо, 2026.09.14–17) оролцсон.
Азийн хөгжлийн банк	Зээлийн ашиглалтыг хянах, эх үүсвэр санхүүжилт олгох, төслийн тайланг шалгах.	Санхүүжилтийн хүсэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, сонгон шалгаруулалтын зөвшөөрөл; хамгаалалтын бодлогын дагуу жендерийн сургалт (2026.06.25).
Монгол Улсын Хөгжлийн банк, Эдийн засаг, хөгжлийн яам	Хувьцаа эзэмшигч; Төрийн бодлого, төсөл хөтөлбөрийн зохицуулалт.	МҮХБ-аас Ногоон хөгжил санд 5.0 сая $-тай тэнцэх хөрөнгө татсан. ЭЗХЯ-тай «Төслийн санхүүжилт» долоо хоногийн арга хэмжээ (II улирал); МҮХБ, ЭЗХЯ-тай «Монгол Улсын хөгжлийн санхүүжилтийн шийдэл» арга хэмжээний хүрээнд «Төслийн санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын боломж» хэлэлцүүлэг (2026.05.07).
НЗДТГ, Төсөл хэрэгжүүлэх нэгж	Төслийн хэрэгжилт, газар чөлөөлөлт, хөгжүүлэгчийн сонгон шалгаруулалт.	Үнэлгээний хороо (А/107, 2026.04.15), Төслийн удирдах хорооны хурал (2026.02.25).
Арилжааны банкууд	Хөгжүүлэгч, өрхүүд, малчид, хоршоод, бизнесүүдэд дэд зээл олгох.	6 банк санамж бичиг байгуулсан; 5 банктай хамтран ажиллах гэрээ байгуулсан; банкуудад зориулсан хэлэлцүүлэг (2026.03.05); гэрээний хэлэлцүүлэг 3-аас олон удаа.

Хамтрагч тал	Үүрэг	Тайлант оны хамтын ажиллагаа
Монголын Ипотекийн Корпораци (МИК)	Ипотекийн зээлийн эх үүсвэрийг хөрөнгө баталгаажуулалтаар дамжуулан санхүүжүүлэх.	Хамтран ажиллах санамж бичиг (2026.06.08); хамтарсан ажлын хэсэг байгуулахаар шийдвэрлэсэн.
Хөгжүүлэгчид	Орон сууц, худалдаа, үйлчилгээний барилга барих.	2025.10-д 30 хөгжүүлэгчийн уулзалт; сонгон шалгаруулах баримт бичиг (захирамж А/674, 2026.05.11).
Сангийн яам	Төрийн санхүүжилт, зээлийн хүсэлтийн баталгаажуулалт.	Эхний татан авалтын 4.15 сая $-ын хүсэлтийг 2026.06.10-нд баталсан. Мөн 4.2 сая $-ын хүсэлтийг хянаж байна.

УАНС-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч болох зорилгын хүрээнд

Компани 2026 оны 9 дүгээр сарын 14–17-ны өдрүүдэд Шри Ланкийн Коломбо хотноо Шри Ланкийн Засгийн газар (Байгаль орчны яам)-тай хамтран зохион байгуулсан УАНС-ийн «Зүүн болон Өмнөд Азийн бүсийн хурал (GCF Regional Dialogue with East and South Asia)»-д оролцсон. Оролцоо нь Компани УАНС-ийн итгэмжлэгдсэн байгууллага (Accredited Entity) болох зорилтынхоо хүрээнд УАНС-ийн удирдлагууд, бүс нутгийн түнш, итгэмжлэгдсэн байгууллагууд, үндэсний эрх бүхий байгууллагуудтай харилцаа тогтоох, УАНС-ийн шаардлага, туршлагыг судлах зорилготой байв.

01 GCF-ийн бүсийн яриа хэлэлцээр — Коломбо, Шри Ланка



Зураг 7. GCF-ийн «Зүүн болон Өмнөд Азийн бүсийн яриа хэлэлцээр»-т оролцсон нь, 2026.09.14–17.

COP 17 үйл ажиллагааны хүрээнд

02 COP17 — хөдөө аж ахуйн хөтөлбөрийн санхүүжилт





Зураг 8. БНХХААБ сангийн нээлтийн арга хэмжээ, COP17 (2026).

03 Монголын ногоон санхүүгийн корпораци (МНСК) — COP17





Зураг 9. МНСК-ийн нээлтийн арга хэмжээ, COP17 (2026).

Бусад хамтын ажиллагааг сайжруулах зорилгын хүрээнд

04 Хөгжлийн түншүүд, банкуудтай хамтарсан арга хэмжээ





Зураг 10. Хөгжлийн түншүүд, банкуудтай хамтарсан арга хэмжээний үеэр.

05 Арилжааны банкуудтай хамтран ажиллах гэрээ, санамж бичиг



Зураг 11. Арилжааны банкуудтай хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулсан нь (Монголын Банкны Холбооны арга хэмжээнд).

06 Монголын Ипотекийн Корпорацитай хамтын ажиллагаа



Зураг 12. Монголын Ипотекийн Корпорацитай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан нь, 2026.06.08.

07 Төслийн санхүүжилтийн түншүүд — Эко хороолол сан



Зураг 13. Төслийн санхүүжилтийн түншүүдтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулсан нь (ЭХОНОС сан).

08 «Үндэсний ногоон лаб»



Зураг 14. «Үндэсний ногоон лаб»-ийн арга хэмжээ. Судалгааны үр дүнд төслийн сан (pipeline) бүрдүүлж байна.



7. Хөгжүүлэх чиглэл

Дараах нь тайлан бэлтгэх явцад илэрсэн чиглэл бөгөөд удирдлагын албан ёсны амлалт биш; хэрэгжүүлэх эсэх, хугацааг дотоод төлөвлөгөөгөөр батална.

01 ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын шинэчилсэн төслийг батлах; хороодын 2025 оны тайланг ирүүлэх; 2026 оны ТУЗ-ийн сургалтын төлөвлөгөө батлах *Засаглал · ХЗХ-ны үүрэг даалгавар (2026.04)*

02 ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, хараат бус байдал, ирцийг жилийн тайланд нийтлэх (хараат бус гишүүний хувь 33.3% — 4.1) *G2.1 · Кодекс 1.3, 2.1*

03 Нэмэлт өгөгдөл цуглуулах: удирдлагын түвшний хүйсийн харьцаа, цалингийн зөрүү, сургалтын цаг, ХАБЭА, ус, хог хаягдал, дулаан *S1, S2, S3, E4, E5 · Хавсралт Б*

04 Оффисын нэг ажилтанд ногдох талбай, цаасны хэрэглээ, эрчим хүчний эрчмийг (кВт·ц/ажилтан) тогтмол хэмжиж, 2027 оны тайланд өмнөх оноор харьцуулах *E1, E5 · 5.1*

05 Scope 1 ба Scope 3 ялгарлын хил хязгаарыг тодорхойлж, ялгарлын коэффициентийг албан ёсны эх сурвалжаар баталгаажуулах *E2 · 5.1*

06 Нийгэм, жендэрийн төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлж, хагас жил тутам тайлагнах *S3, S5 · 6.2*

07 Түнш банкуудтай хамтран ажиллах гэрээнд БОНЗ-ын эрсдэлийн шалгуур, хориотой үйл ажиллагааны жагсаалтыг тусгаж, нийт гүйлгээний хувийг тайлагнах *FS2, FS3 · 6.3*

08 2018–2019 оны журмуудыг (Комплайнсын А-11, Ёс зүйн хорооны А-30) ҮЦК-ийн статусаас ХОМК-ийн статус болсонтой уялдуулан шинэчлэх, Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг баталгаажуулах *G1.1, G3 · 4.5*

09 Журмын хэрэгжилтийн үзүүлэлт: ёс зүйн гомдлын тоо ба шийдвэрлэсэн хувь, мөнгө угаахтай тэмцэх сургалтад хамрагдсан ажилтны тоо, сэжигтэй гүйлгээний мэдээлэл *G1, G3, S5.5 · 4.3*

10 Уур амьсгалын эрсдэл, боломжийн (TCFD/IFRS S2) үнэлгээг сангийн түвшинд боловсруулах *MS5.1, E3 · 3, 5.2*

11 Хүний нөөцийн эргэцийг тооцох томьёог тодорхойлж, ажлаас гарсан шалтгаан, сургалтын цаг (ажилтан тус бүрээр), ажилтны сэтгэл ханамжийг тогтмол хэмжих *S1.1, S1.3 · 6.1*

12 Ач холбогдолтой сэдвийн үнэлгээг оролцогч талуудын санал асуулгаар баталгаажуулж, ТУЗ-өөр хэлэлцүүлэх *MS1, MS5 · 3.3*

13 СЗХ-ны 2026.06.08-ны зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилтийг (ТУЗ-ийн журам, төлөөллийн гэрээ, БОНЗ-ийн агуулга) оны эцэст нотлох баримтын хамт хүргүүлэх *G1, G2 · 4.2*

ХАВСРАЛТ

A

Хавсралт A. GRI ба ISSB лавлагаа

Байгууллагын танилцуулга	GRI 2-1 – 2-5
Засаглал, ёс зүй	GRI 2-9 – 2-27 (2-23 бодлогын амлалт, 2-26 зөвлөгөө, санаа зовнил илэрхийлэх механизм) · 4.1–4.3; G1.1, G2, G3
Авлигын эсрэг, мөнгө угаахтай тэмцэх	GRI 205-1, 205-2 · 4.3; G1.1, G3.1
Ялгаварлан гадуурхахгүй байх	GRI 406 · 4.3, 6.1; S3.3
Оролцогч талууд	GRI 2-29; GRI 413 · 6.3; S5
Эрчим хүч	GRI 302 · 5.1; E1
Ялгарал	GRI 305 · 5.1; E2
Уур амьсгалын эрсдэл	GRI 201-2; IFRS S2; TCFD · 3, 5.2; E3
Хүний нөөц, сургалт	GRI 401, 404 · 6.1; S1
Жендэр, хүртээмж	GRI 405; ТХЗ 5, 10 · 6.2; S3, S4
Худалдан авалт, түнш сонгох	GRI 204, 308, 414 · 6.3; S6